



“ГЕРМЕС ЦЕНТР” ХК

**ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2021 ОН**



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Оноосон нэр: “Гермес центр” хувьцаат компани	
Улсын бүртгэлийн дугаар: 9010001069	
Регистрийн дугаар: 277 3678	
Үүсгэн байгуулагдсан огноо: 2003 оны 07-р сарын 22-ны өдөр	
Үйл ажиллагааны чиглэл: Түрээсийн	
Компанийн албан ёсны хаяг: УБ хот, Баянгол дүүрэг 25-р хороо, Нарны зам 20, 20/1, өөрийн байр	
Компанийн удирдлага: ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн, Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	
Дүрмийн сан: 7 854 300 100 төгрөг	
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 982 хувьцаа эзэмшигчидтэй. (2021 оны 03-р сарын 11-ний бүртгэлийн өдрөөр)	
Холбоо барих утас: 11-30-15-77	
Вэб хуудас: www.hermescenter.mn	



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Энэ 2021 онд манай компани нь батлагдсан орон тоогоор буюу 16 ажилтан, ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Гүйцэтгэх удирдлагын баг нь эхний улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Компанийн нийт ажиллагсадтай 2021 онд хөдөлмөрийн гэрээгээ шинэчлэн байгуулж, ажиллагсдын ажлыг “Ажилтны үнэлгээний хуудас”-аар улирал тутамд дүгнэж байна.
2. Худалдааны төвийн түрээслэгчидтэй байгуулсан 2020 оны түрээсийн гэрээний гүйцэтгэлийн явцын үнэлгээг түрээслэгч тус бүртэй хамтран дүгнэж, түрээсийн хөнгөлөлтийг ялгавартайгаар (0%-10%) үзүүлэн давхардсан тоогоор нийт 222 түрээслэгч иргэд, байгууллагатай түрээсийн гэрээг шинэчилж байгуулсан. Түрээслэгчдийн бараа материалыг даатгалд бүрэн хамруулсан бөгөөд түрээсийн талбай 100 хувь түрээслэгдсэн болно.
3. Коронавирусын халдварт өвчний дотоодын тархалт өндөр байсантай холбоотойгоор хатуу хөл хорионы дэглэм тогтоосны улмаас худалдааны төв дараах өдрүүдэд хаалттай байсан. Үүнд:

1-р сард 9 хоног,

2-р сард 9 хоног,

4-р сард 21 хоног,

5-р сард 7 хоног нийт 46 хоног худалдааны төв ажиллалаагүй болно.

Эдгээр ажиллалаагүй өдрүүдийн түрээсийн төлбөрийг түрээслэгчидтэй байгуулсан гэрээний дагуу 60 хувийн хөнгөлөлтийг үзүүлж, 40 хувийн түрээсийн төлбөрийг түрээслэгчдээс нэхэмжилж авлаа.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААР

4. Коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор худалдааны төвд сардаа нэгээс хоёр удаа мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол хийлгэж байна. Мөн компанийн ажиллагсад долоо хоног бүр 2 удаа халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж, ариутгалын байдлыг бий болгож байна.
5. БГД-ийн Эрүүл мэндийн төв, Худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран нийт 500 гаруй компанийн ажилтан ажиллагсад болон худалдааны төвийн түрээслэгч, тэдгээрийн худалдагч туслах ажилтнуудыг дархлаажуулалтын 2 тунд бүрэн хамрууллаа.
6. УОК-ын даргын 2021 оны 5-р сарын 6-ны өдрийн 41 тоот тушаалаар батлагдсан “Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын дагуу худалдааны төвд нэвтэрч байгаа түрээслэгчид, тэдгээрийн худалдагч, туслах ажилтнууд болон худалдан авагч, үйлчлүүлэгчдийг шалган нэвтрүүлэх хяналтын ажилтныг томилж, хувийн тусгай хамгаалах хэрэгслээр ханган ажиллаж байна. Мөн сэжигтэй тохиолдлыг тусгаарлах тусгаарлалтын өрөөг бэлтгэж, шаардлагатай эм, эмнэлгийн анхан шатны тусламжийн иж бүрдэл, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүллээ.
7. Коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн баримтлахтай холбоотойгоор мэргэжлийн байгууллагуудаас гаргасан заавар зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААР

8. БГД-ийн Онцгой байдлын хэлтсээс 2021 оны галын аюулгүй ажиллагааны дүгнэлтийг гаргуулан авлаа.
9. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг УОКомиссын шийдвэрийн дагуу хосолсон хэлбэрээр 2021 оны 4-р сарын 9-ний өдөр хуралдуулсан бөгөөд хурлын материалыг холбогдох журмын дагуу СЗХороо, МХБиржид тус тус хүргүүлсэн. Хувьцаа эзэмшигчдийн талаарх судалгааг сүүлчийн бүртгэлийн өдрөөр хийж гүйцэтгэлээ.
10. Компанийн шинэчилсэн дүрмийг СЗХороогоор хянуулж, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн. Мөн компанийн оршин суугаа хаяг өөрчлөгдсөнтэй холбогдуулан улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох өөрчлөлтүүдийг оруулж албажууллаа.
11. Компанийн веб сайтын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж байна
12. Худалдааны төвийн барилга, гадна талбайд дараах аж ахуйн шинж чанартай ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд :
 - Худалдааны төвийн хашааны авто зогсоолын хагарсан асфальтан зам талбайг засварласан. Нийт 11.0 сая төгрөг болсон.
 - Худалдааны төвийн авто зогсоолын хагарч, бутарсан бетонон зам талбайг өөрсдийн ажиллагсдаар бетондуулж засварлуулсан.
 - Худалдааны төвийн авто замын хагарсан брожуруудыг сольж, будуулсан.
 - Худалдааны төв рүү цахилгаан дамжуулдаг 10 кв-ын хос кабель шугам 2 удаа гэмтсэн бөгөөд гэмтлийг засварлах ажлыг “УБЦТС” ТӨХК-ийн харьяа Баруун түгээх төвөөр хийлгэж, цахилгааны утас, муфть болон холбогч эд ангиудыг солиулсан. Нийт 6.5 сая төгрөгийн зардал гарсан.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААР

- Худалдааны төвийг хэрэгцээний халуун усаар хангадаг халуун усны төв шугамд гэмтэл гарсныг мэргэжлийн байгууллагаар засварлуулсан. Нийт 9.0 сая төгрөгийн зардал гарсан.
 - Хөрөнгө оруулалтын төсвийн хүрээнд худалдааны төвийн дотор талын аналог системийн 48 камер шинэчилж солих, гадна талбайд өндөр хүчин чадалтай 1 камерыг шинээр суурилуулах ажлын гэрээг байгуулсан. Гэрээний нийт үнийн дүн 14.8 сая төгрөг болсон.
 - Худалдааны төвийн Б корпусын дээврийн ус гоождог хэсэгт борооны улирал эхлэхээс өмнө засварыг хийлгэсэн.
 - Хог хаягдлын менежментээ сайжруулах ажлын хүрээнд худалдааны төвийн хогийн савыг хувааж, түрээслэгчдийг хог хаягдлаа ангилж хаях боломжийг бүрдүүлсэн.
 - 1, 2, С давхруудад тухай бүр гарсан барилгын жижиг засварын ажлуудыг хийж байлаа.
13. Татварын байгууллагад төлөх ёстой татвараа хугацаанд нь төлж байна. Үүний үр дүнд Сангийн яам, Татварын ерөнхий газраас манай компанийг Монгол улсын хууль тогтоомжийг шударгаар сахиж, улс орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсныг өндрөөр үнэлж, 2020 оны “Шилдэг татвар төлөгч”-өөр шалгарууллаа



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААР

14. Түрээслэгчдэд сар бүр тогтмол захидал хүргүүлж байна. Түрээслэгчдийн зүгээс тавьсан санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ирлээ. УОК-ын даргын 41 тоот тушаалаар батлагдсан Коронавируст халдвараас сэргийлэх, арга хэмжээг зохион байгуулах түр журмын хавсралт “Зах худалдааны төв, их дэлгүүр агуулах худалдаа, хайпермаркет, супермаркетын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлага”-ын дагуу түрээслэгч нарт сар бүр хүргүүлж байгаа албан захидлаар дамжуулан коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өдөр тутам амны маск хэрэглэх, гараа сайтар савандаж угаах, гар дээрээс халуун хоол унд болон бусад бараа бүтээгдэхүүнийг худалдан авахгүй байх, ажлын байран дээр хооллохгүй байх, лангуу павильон тус бүрт хүн хоорондын зай баримтлах тэмдэг, тэмдэглэгээ хийх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, төлбөр тооцоо хийх хэсэгт тусгаарлах шилэн болон хуванцар хаалт хийх, өөрсдийн биеийн дархлаагаа сайжруулах амин дэм хэрэглэх, нус цэр шүлс тамхины ишээ ил задгай хаяхгүй байх, олон нийтийн сүлжээгээр гарч байгаа буруу ташаа мэдээлэлд автахгүй байх, бусдад худал мэдээлэл тарааж, айдас хүйдэст автуулахгүй байхыг захиргааны зүгээс байнга анхааруулан зөвлөж байна.
15. Худалдааны төвийн захиргаа нь Голомт банктай хамтран Засгийн газраас хэрэгжүүлж буй ажлын байрыг дэмжих зээлийн талаарх мэдээллийг өгөх зорилгоор түрээслэгчдийн дунд уулзалт өдөрлөгийг зохион байгууллаа.
16. Худалдааны төвийн гадна талбайн мод зүлэг, ногоон байгууламжийг байнга тордож, арчилж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААР

17. Худалдааны төвийн авто зогсоолын хүрэлцээг худалдан авагч, үйлчлүүлэгчдэд хүрэлцээтэй байлгах зорилгоор түрээслэгч тэдгээрийн худалдагч, туслах ажилтнуудын авто машиныг нэвтрүүлэхгүй байхаар шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Ингэснээр авто зогсоолын хүрэлцээ харьцангуй сайжирч байна.
18. Компанийн ажиллагсдад сар тутам хурал хийж, мэдээ мэдээллийг танилцуулан, харилцан зөвшилцөх зарчмаар ажлаа явуулж байна.



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР



1. “Термес Центр” ХКомпанийн эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүдийг танилцуулахад нийт хөрөнгө 8 669.4 сая төгрөг. Үүнээс:
 - Эргэлтийн хөрөнгө 2 358.0 сая төгрөг
 - Эргэлтийн бус хөрөнгө 6 284.4 сая төгрөг
 - Эзэмшигчийн өмч хөрөнгө 8 432.0 сая төгрөг
 - Тайлант үеийн цэвэр ашиг 514.1 сая төгрөг байна.
2. Татварын өр төлбөрийн тухай :

Манай компани нь 2021 оны эхний хагас жил улсад 156.1 сая төгрөгийн татварыг төлөөд байна. Үүнд:

- ААН-ийн ОАТатварт 20.9 сая төгрөг,
- Ажиллагсдын цалингаас суутгасан хувь хүний ОАТатварт 11.2 сая төгрөг,
- НДШимтгэлд 26.0 сая төгрөг,
- НӨАТатварт 55.4 сая,
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 13.9 сая төгрөг,
- Газрын татварт 5.9 сая төгрөг
- Ногдол ашгийн татварт 22.8 сая төгрөг



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3. Орлогын тухай :

Манай компани 2021 оны эхний хагас жилд нийтдээ 673.1 сая төгрөгийн борлуулалтын, 208.8 сая төгрөгийн хадгаламжийн хүүний орлоготой ажиллалаа. Нийт орлогын хэмжээ 881.9 сая төгрөг байна. Коронавирусын халдварт өвчний улмаас хатуу хөл хорионы дэглэмд шилжиж худалдааны төв нийт 46 хоног хаалттай байсантай холбогдуулан борлуулалтын орлого 136.8 сая төгрөгөөр буюу 17 %-иар тасалдлаа.

4. Зардлын тухай :

Компани 362.2 сая төгрөгийн зардалтай ажилласан. Гүйцэтгэх удирдлагын багийн зүгээс зардлыг 25%-иар хэмнэн ажиллалаа.

5. Ашгийн тухай :

Компанийн эхний хагас жилийн ашгийн төлөвлөгөө 535.0 сая төгрөг байснаас 514.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Ашгийн биелэлт 96%-ийн биелэлттэй байна.

6. Ногдол ашгийн тухай :

Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 6 төгрөг 55 мөнгө болж байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТАЛААР

Манай компани нь 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 4-р сарын 9-ний өдөр хосолсон хэлбэрээр зохион байгууллаа. Хуралд нийт 67 293 864 ширхэг саналын эрхтэй 8 хувьцаа эзэмшигч (танхимаар 6, цахимаар 2) оролцлоо. Хурлын ирц 85.68 хувьтай байлаа. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталлаа. Үүнд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлав.
2. Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид сайшаан тэмдэглэв.
3. Компанийн 2019 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2020 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2021 оны ногдол ашгийг хуваарилах тухай мэдээллийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид сайшаан тэмдэглэв.
4. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай танилцуулав.
5. Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилтыг хувьцаа эзэмшигчид сайшаан дэмжив.
6. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай асуудлыг хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар тогтоолыг батлав. Үүнд:



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТАЛААР

ТУЗ-ийн ердийн гишүүдээр :

- Д.Оюунсүрэн
- Б.Оюунцэцэг
- Д.Алтанчимэг
- Б.Амарсанаа
- Н.Мөнхзул
- Ц.Түвшинжаргал нарыг,

Хараат бус гишүүдээр :

- Д.Туяа
- Н.Батсайхан
- Б.Алтангэрэл нарыг сонголоо.

7. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын 2020 оны цалин урамшууллын зардлын гүйцэтгэлийг тайлагнаж, 2021 оны ТУЗ-ийн цалингийн зардлыг баталлаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн баталсан тогтоол шийдвэр, хурлын материалыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн. Мөн хурлын мэдээллийг Монголын хөрөнгийн биржийн сайтанд байршуулсан.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ



“Гермес Центр” ХКомпани нь 2021 оны 03-р сарын 11-ний бүртгэлийн өдрөөр 982 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд үүнээс:

- 28 хувьцаа эзэмшигчид нь аж ахуйн нэгж, байгууллага байгаа бөгөөд тэдгээр нь 5 921 743 ширхэг хувьцаа эзэмшиж, нийт хувьцааны 7.5 %-ийг,
- 954 хувьцаа эзэмшигчид нь иргэд байгаа бөгөөд тэдгээр нь 72 621 258 ширхэг хувьцааг эзэмшиж, нийт хувьцааны 92.5%-ийг тус тус эзэмшиж байна.

Мөн хувьцаа эзэмшигч 954 иргэдийн хувьд:


- 29 хувьцаа эзэмшигчид нь гадаадын иргэд байгаа бөгөөд тэдгээр нь 2 841 001 ширхэг хувьцаа эзэмшиж, нийт хувьцааны 3.9 %-ийг,
- 925 хувьцаа эзэмшигчид дотоодын иргэд байгаа бөгөөд тэдгээр нь 69 780 257 ширхэг хувьцаа эзэмшиж, нийт хувьцааны 96.1 %-ийг тус тус эзэмшиж байна.



КОМПАНИЙН 4-ӨӨС ДЭЭШ БАГЦЫГ ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААР



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



Нийт хувьцааны тоо:

78 543 001

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо:

(2021 оны 03-р сарын 11-ний

бүртгэлийн өдрөөр)

982

- Д.Зоригт
- Д.Оюунсүрэн
- "Impera Mongolia" ХХК
- Бусад



ХАЯГ, ХОЛБОО БАРИХ АЖИЛТАН

1. Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам – 20, “Гермес центр” ХК-ийн төв оффисын байр болон барилгын материалын Гермес худалдааны төв
2. Вэб хаяг: www.hermescenter.mn
3. Холбогдох утас: 976 – 11 – 30 15 77
4. Холбоо барих албан тушаалтан:
 - Нягтлан бодогч О.Энхтуяа
 - Мэргэжилтэн Д.Эрдэнэсүрэн